



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/188

Мандалговь

Говийн бүсийн хүүхдийн урлагийн их
наадам зохион байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.5, Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн 2.2.2, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хүүхэд өсвөр үеийнхэнд Монгол үндэстний урлагийн их өв санг түгээн дэлгэрүүлэх, эзэмшүүлэх, өвлүүлэх, сурталчлах, тэдний авьяас чадварыг хөгжүүлэх, харилцан суралцах, хамтран уран бүтээл туурвих, үндэстний соёл урлаг, зан заншлаараа бахархах үзлийг төлөвшүүлэх зорилгоор "МОНГОЛЫН ХҮҮХДҮҮД" говийн бүсийн хүүхдийн урлагийн их наадмыг 2019 оны 5 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

Хоёр. "МОНГОЛЫН ХҮҮХДҮҮД" говийн бүсийн хүүхдийн урлагийн их наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: А.Нарантуяа (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: Ц.Ганзориг (Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга)

Гишүүд: Ц.Бумангэрэл (Боловсрол, соёл, урлагийн газрын дарга)

А.Ууганбаяр (Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын дарга)

Т.Туяамандах (Эрдмийн далай цогцолбор сургуулийн захирал)

Д.Эрдэнэболд (Говийн ирээдүй цогцолбор сургуулийн захирал)

М.Энхбаяр (Мандал сургуулийн захирал)

Гурав. "МОНГОЛЫН ХҮҮХДҮҮД" говийн бүсийн хүүхдийн урлагийн их наадмыг чанартай зохион байгуулж, тайлагнахыг ажлын хэсэг (А.Нарантуяа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190503